

Эрдэнэ Ресурс нь өндөр агуулга бүхий Хөндий алтны төслийн нөөцийн тооцооллыг танилцууллаа

Канад улс, Нова Скошиа муж, Халифакс хот – 2018 оны 9-р сарын 18

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (цаашид “Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь Монгол улсын баруун өмнөд зүгт байрлах өөрийн 100% эзэмшлийн Хөндий алтны төслийн нөөцийг Канад улсын нөөц тайлагнах NI 43-101 (“National Instrument 43-101” эсвэл “NI 43-101” гэх) тайлагналын стандартын дагуу олон нийтэд танилцуулахад таатай байна.

Хөндий алтны төсөл нь хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий алтны орд болон Алтан Нар алтны ордуудыг хамардаг. Энэхүү хэвлэлийн мэдээгээр 2018 оны 5-р сард танилцуулсан Алтан Нар ордын нөөцийн хэмжээг үнэмлэхүй хэмжээгээр нэмж шинэчилсэн нөөцийн тайланг Баян Хөндий ордын нөөцийн тайлантай нэгтгэн танилцуулж байна. Дээрх хоёр орд нь шинээр илрүүлсэн Хөндий алтны дүүрэгт оршдог бөгөөд эрдэсжилт нь газрын гадаргаас ойр, өндөр агуулгатайгаараа онцлог юм.

Нөөцийн тайлангийн онцлох мэдээ (Хавсаргасан материалтай танилцана уу)

- Хөндий алтны төслийн нийт нөөц:
 - 2.3 г/т алтны дундаж агуулга бүхий 751,000 унц алтны бодит нөөц,
 - 1.8 г/т алтны дундаж агуулга бүхий 291,000 унц алтны боломжит нөөц
- 1.4 г/т алтны захын агуулгаар тооцвол Хөндий алтны төсөл нь:
 - 3.7 г/т алтны дундаж агуулга бүхий 642,000 унц алтны бодит нөөц, үүнд Баян Хөндий ордын 5.2 г/т алтны дундаж агуулга бүхий 357,000 унц бодит нөөц багтаж байна.
- Хөндий алтны төслийн полиметалл болон үнэт металлыг агуулснаар:
 - 2.7 г/т AuEq (алтны дүйцэх нэгж буюу “алтны эквивалент”) агуулгатай 886,000 унц бодит нөөц,
 - 2.3 г/т AuEq агуулгатай 382,000 унц боломжит нөөц агуулагдаж байгааг танилцуулаа.
- Эрдэнэ Ресурс нь Хөндий алтны төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг хийж эхлүүлсэн бөгөөд 2018 оны 4-р улиралд эцэслэхээр төлөвлөж байна.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал Петер Акерли: “Баян Хөндийн нөөцийн тайлан нь бидний зорилтот хэмжээнд хүрч, алтны дундаж агуулга нь дэлхийн алтны ил уурхайнуудтай харьцуулахад өндөр байгааг танилцуулахад таатай байна.”

“Хөндий алтны дүүрэг дэх Алтан Нар, Баян Хөндий ордууд нь өндөр агуулгатай, газрын гадаргад ойр хүдрийн биетүүдтэйгээс гадна металлургийн нөхцөл нь цаашид эдгээр ордуудыг нэгдсэн байдлаар хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж байна. Бид энэ оны төгсгөлд дээрх хоёр нөөцийн тайлангийн үр дүнг багтаасан Хөндий алтны төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг боловсруулж, 2019 оны эхээр ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэхээр төлөвлөж байна. Үүний зэрэгцээ бид шинээр илрүүлсэн алтны дүүрэгт шинэ ордуудыг хайн илрүүлэх хайгуулын өрөмдлөгийн ажлуудыг үргэлжлүүлэхээр төлөвлөсөн.”

Энэхүү хэвлэлийн мэдээг олон нийтэд мэдээлснээс 45 хоногийн дотор NI 43-101 техникийн тайланг SEDAR, www.sedar.com -д танилцуулна.

Нөөцийн тайлангийн тойм

Баян Хөндий орд нь Алтан Нар алт-полиметаллын ордоос зүүн-өмнө зүгт 16 км зайд байрладаг ба Алтан Нар ордын нөөцийг 2018 оны 5-р сарын 10-нд шинэчлэн танилцуулсан (хэвлэлийн мэдээтэй [эндээс](#) танилцана уу). Энэхүү хоёр нөөцийн тайланг нэгтгэн нэг төсөл буюу “Хөндий Алтны Төсөл” гэх бөгөөд ирээдүйд хийгдэх техник, эдийн засгийн судалгаануудад Хөндий Алтны Төслийн Нөөцийн Тайлан хэмээн тайлагнана. (Хүснэгт 1)

Баян Хөндийн нөөцийн тайлан (“Нөөцийн тайлан”) нь RPMGlobal Asia Limited (“RPM”)-ээр NI 43-101 стандартын дагуу бэлтгэгдэн, 2018 оны 9 сарын 12-ны өдрөөр батлагдав. Нөөцийн үзүүлэлтүүдийг (Хүснэгт 2) Эрдэнэ Ресурсийн RPM-д хүргүүлсэн мэдээлэлд тулгуурлан бэлдсэн бөгөөд тодорхой мэдээллүүдийг RPM баталгаажуулсан. Нөөцийн тооцоолол болон статистикийн судалгааг RPM хийж гүйцэтгэсэн. NI 43-101 нөөцийн тайлан болон техникийн тайлангуудыг 45 хоногийн дотор SEDAR-т тайлагнана. Нөөцийн тайланд 2015 оны 4-р улирлаас 2018 оны 2-р улиралд хийсэн 42,656 метрийн 255 алмазан өрмийн үр дүн багтсан. Мөн нөөцийн тайлан нь 1.2 км (Зүүн Хойд-Баруун Урд) болон 200-400 метр (Баруун Хойд-Зүүн Урд) талбайн газрын гадаргад ойр, өндөр эрдэсжсэн (2,200 г/т хүртэл алтны агуулга) системийг хамарсан. Баян Хөндийн нөөцийн тооцоололд өндөр агуулга бүхий хүдрийн бүсийн (8 г/т-оос 250 г/т хүртэл) дундаж агуулгын дээд хязгаарыг 51 г/т харин бага агуулга бүхий хүдрийн бүсийн дундаж агуулгын дээд хязгаарыг 1.5 г/т агуулгаар тооцсон.

RPM нь нөөцийн тайланд хэд хэдэн захын агуулгыг тооцоолсон боловч Баян Хөндийн тайланд 0.6 г/т захын агуулга, Алтан Нарын тайланд илээр ашиглах нөөцийн захын агуулгыг 0.7 г/т, харин ил уурхайгаас доош орших нөөцийн захын агуулгыг 1.4 г/т-оор тооцоолохыг зөвлөсөн. Захын агуулгын хувилбаруудад хийсэн нөөц агуулгын хамаарлын мэдрэмтгий байдлын шинжилгээний үр дүнг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. Хөндий алтны төслийн нөөцийн тайлан, 2018 оны 9-р сарын 12-ны байдлаар (захын агуулгын төрлүүдээр, зөвхөн алт болон алтны дүйцэх нэгжээр хэмжигдсэн)

Захын агуулга ⁽¹⁾	Нөөцийн тодруулга	Хэмжээ (Сая тон)	Агуулга Au г/т	Алт 000 унц	Агуулга AuEq г/т	AuEq 000 унц
0.2	Баттай (Measured)	4.3	1.4	194	1.4	194
	Бодит (Indicated)	19.3	1.1	710	1.4	852
	Баттай бодит нөөц (Measured & Indicated)	23.6	1.2	904	1.4	1,046
	Боломжит (Inferred)	16.8	0.8	416	1.0	511
0.4	Баттай (Measured)	2.4	2.3	177	2.3	177
	Бодит (Indicated)	12.7	1.6	647	2.0	788
	Баттай бодит нөөц (Measured & Indicated)	15.1	1.7	824	2.0	965
	Боломжит (Inferred)	8.6	1.2	342	1.6	436
Санал болгосон захын агуулгаар ⁽²⁾	Баттай (Measured)	1.4	3.6	161	3.6	161
	Бодит (Indicated)	8.7	2.1	590	2.6	725
	Баттай бодит нөөц (Measured & Indicated)	10.1	2.3	751	2.7	886
	Боломжит (Inferred)	5.2	1.8	291	2.3	382
1.0	Баттай (Measured)	0.8	5.6	148	5.6	148
	Бодит (Indicated)	6.0	2.8	530	3.4	655
	Баттай бодит нөөц (Measured & Indicated)	6.8	3.1	678	3.7	803
	Боломжит (Inferred)	3.9	2.1	261	2.9	349
1.4	Баттай (Measured)	0.8	5.9	145	5.9	145
	Бодит (Indicated)	4.7	3.3	497	4.1	610
	Баттай бодит нөөц (Measured & Indicated)	5.5	3.7	642	4.3	755
	Боломжит (Inferred)	3.4	2.3	250	3.0	333

(1) Алтан Нарын захын агуулга нь алттай дүйцэх нэгжээр, Баян Хөндий нь зөвхөн алтаар хэмжигдсэн

(2) Баян Хөндийн тайланд 0.6 г/т захын агуулга, Алтан Нарын тайланд илээр ашиглах нөөцийн захын агуулгыг 0.7 г/т харин ил уурхайгаас доош орших нөөцийн захын агуулгыг 1.4 г/т-оор тооцоолохыг зөвлөсөн

* Ордуудын тус бүрийн нөөцийн тайлангийн тухай 2, 3-р хүснэгт дэх тэмдэглэлээс харна уу.

Ордуудын нөөцийн тайлангийн тухай

Баян Хөндий ордын анхан шатны нөөцийн тайлангийн тухай мэдээллийг Хүснэгт 2-т танилцуулав. Анхан шатны нөөцийн тайланг боловсруулахад захын агуулгын хувилбаруудыг ашигласан боловч RPMGlobal нь 0.6 г/т алтны захын агуулгаар тайлагнахыг санал болгосон болно.

Хүснэгт 2. Баян Хөндий ордын анхан шатны нөөцийн тайлан, 2018 оны 9-р сарын 12-ны байдлаар

Захын агуулга ⁽¹⁾	Нөөцийн тодруулга	Хэмжээ (Сая тонн)	Агуулга Au г/т	Алт 000 унц
0.2	Баттай (Measured)	4.3	1.4	195
	Бодит (Indicated)	13.5	0.9	384
	Баттай бодит нөөц (Measured & Indicated)	17.8	1.0	579
	Боломжит (Inferred)	12.7	0.6	225
0.4	Баттай (Measured)	2.4	2.3	177
	Бодит (Indicated)	7.1	1.4	324
	Баттай бодит нөөц (Measured & Indicated)	9.5	1.6	501
	Боломжит (Inferred)	4.9	1.0	153
0.6	Баттай (Measured)	1.4	3.6	161
	Бодит (Indicated)	3.7	2.3	272
	Баттай бодит нөөц (Measured & Indicated)	5.1	2.6	433
	Боломжит (Inferred)	1.8	1.9	105
1.0	Баттай (Measured)	0.8	5.6	148
	Бодит (Indicated)	1.8	4.0	224
	Баттай бодит нөөц (Measured & Indicated)	2.6	4.5	372
	Боломжит (Inferred)	0.7	3.8	79
1.4	Баттай (Measured)	0.8	5.9	145
	Бодит (Indicated)	1.4	4.7	212
	Баттай бодит нөөц (Measured & Indicated)	2.2	5.2	357
	Боломжит (Inferred)	0.5	4.4	74

(1) Тэмдэглэл:

- Энэхүү нөөцийн тайлан дахь мэдээллүүд нь RPM-ийн ажилтан, Австралийн Геосудлаачдын Институтын гишүүн Жереми Кларк (Jeremy Clark)-ийн хяналт дор боловруулагдсан. Ноён Кларк нь дурдсан ордын эрдэсжилтийн талаар өндөр туршлагатай бөгөөд CIM Тодруулгын стандартын дагуу Мэргэшсэн этгээдийн шаардлага хангасан мэргэжилтэн юм.
- Нөөцийн тайлангийн талаар дээрх хүснэгтэд багтсан мэдээлэл нь 2018 оны 6-р сарын 27 хүртэл хийгдсэн өрмийн судалгааны үр дүнд тулгуурласан. Нөөцийн тайлан нь нарийн өгөгдөл биш бөгөөд судалгааны үр дүн, байршил, хэлбэр болон тархац зэрэг хязгаарлагдмал мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан. Дээр өгөгдсөн өгөгдлүүд нь тооцооллын харьцангуй байдалд тулгуурлан бүхэл тоонд шилжүүлсэн болно. Үүнээс шалтгаалсан тооцооллын зөрүү гарах магадлалтай.
- Нөөц нь хуурай ба газар доорх байдлаар тооцоологдсон
- Эрдсийн нөөц нь 0.6 г/т-ын захын агуулгаар бодогдсон. Энэхүү захын агуулгыг RPM компани сонгохдоо ил аргаар олборлох алтны үнэлгээ нь 1500 ам.доллар/унц байх ба олборлолтын зардал тонн хүдэр тутамд 6 ам.доллар хүдэр боловсруулалтын зардал нь тонн тутамд 20 ам.доллар бөгөөд металл авалт нь 95% байна хэмээн төсөөлжээ.
- Дээр дурдсан нөөцийн тайлан нь ямарваа нэгэн эдийн засгийн тооцоололд харьяалагдаагүй бөгөөд эдийн засгийн бодит чанарыг агуулаагүй болно.

Алтан Нар алт-полиметаллын ордын анхан шатны нөөцийн тайлангийн тухай мэдээллийг Хүснэгт 3-аас харна уу. Энэхүү нөөцийн тайлангийн тухай илүү дэлгэрэнгүйтэй Компанийн 2018 оны 5-р сарын 10-нд танилцуулсан хэвлэлийн мэдээнээс танилцаж болно. ([Хэвлэлийн мэдээ](#))

Хүснэгт 3. Алтан Нар орд – Нөөцийн тайлангийн тойм, 2018 оны 5 сарын 7

Захын агуулга AuEq г/т	Нөөцийн тодруулга	Хэмжээ (сая тонн)	Агуулга					Агуулж буй металл				
			Au г/т	Ag г/т	Zn г/т	Pb г/т	AuEq г/т	Au 000 унц	Ag 000 унц	Zn 000 тонн	Pb 000 тонн	AuEq 000 унц
0.4	Бодит	5.6	1.8	13.5	0.6	0.5	2.6	323	2,412	33.2	29.9	464
	Боломжит	3.7	1.6	7.5	0.7	0.6	2.3	189	901	24.5	22.8	283
0.7	Бодит	5.0	2.0	14.8	0.6	0.6	2.8	318	2,350	31.6	29.0	453
	Боломжит	3.4	1.7	7.9	0.7	0.7	2.5	186	866	23.7	22.3	277
1.0	Бодит	4.2	2.3	16.6	0.7	0.7	3.2	306	2,212	28.6	27.4	431
	Боломжит	3.2	1.8	8.2	0.7	0.7	2.7	182	837	22.8	21.5	270
1.4	Бодит	3.3	2.7	18.9	0.8	0.8	3.8	285	2,002	24.9	25.2	398
	Боломжит	2.9	1.9	8.6	0.8	0.7	2.8	176	795	21.5	20.4	259

Тэмдэглэл:

1. Эрдсийн нөөц нь гүнээр хязгаарлагдсан бөгөөд илээр ашиглах боломжтой нөөцийн захын агуулга нь 0.7 г/т харин гүний нөөцийн захын агуулга нь 1.4 г/т-оор тооцоологдсон.
2. Энэхүү нөөцийн тайлан дахь мэдээллүүд нь RPM-ийн ажилтан, Австралийн Геосудлаачдын Институтын гишүүн Жереми Кларк (Jeremy Clark)-ийн хяналт дор боловсруулагдсан. Ноён Кларк нь дурдсан ордын эрдэсжилтийн талаар өндөр туршлагатай бөгөөд CIM Тодруулгын стандартын дагуу Мэргэшсэн этгээдийн шаардлага хангасан мэргэжилтэн юм.
3. Нөөцийн тайлангийн талаар дээрх хүснэгтэд багтсан мэдээлэл нь 2018 оны 5-р сарын 7 хүртэл хийгдсэн өрмийн судалгааны үр дүнд тулгуурласан. Нөөцийн тайлан нь нарийн өгөгдөл биш бөгөөд судалгааны үр дүн, байршил, хэлбэр болон тархац зэрэг хязгаарлагдмал мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан. Дээр өгөгдсөн өгөгдлүүд нь тооцооллын харьцангуй байдалд тулгуурлан бүхэл тоонд шилжүүлсэн болно. Үүнээс шалтгаалсан тооцооллын зөрүү гарах магадлалтай.
4. Нөөцийн тайлан дах агуулгыг CIM стандартын дагуу тайлагнасан.
5. Нөөц нь хуурай ба газар доорх байдлаар тооцоологдсон
6. Нөөцийн тайланд хүдэр алдалт болон бохирдолтын хүчин зүйлийг тусгаагүй болно.
7. Цаашид ашиглалтын үйл явцад гарч болзошгүй боловсруулалтын явцад гарч болох металл алдалтын талаар төсөөлөл хийгээгүй
8. Алтны дүйцэх нэгжийг (“AuEq”) алтыг нэг унц 1,310 ам.доллар, мөнгийг нэг унц 18 ам.доллар, хар тугалгыг нэг тонныг 2,400 ам.доллар болон цайрыг нэг тонныг 3,100 ам.доллар байхаар тооцоолов.

Хөндий алтны төслийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Энэхүү Төв Азийн Орогены бүс нь БНХАУ-ын нутагт хил дагуу болон бүсийн баруун чиглэлд эпиптермаль алт болон порфирийн зэс-алтны ордууд сайн судлагдсан байдаг боловч Монгол улс нь 1990-ээд оны дунд үеэс ардчилсан нийгэмд шилжин, гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад хайгуул хийх боломжийг бий болгосноор судлагдаж эхэлсэн. Ийнхүү

судлагдсанаар дэлхийн хэмжээний алт-зэсийн орд болох Оюу Толгойг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд бүсэд 10 гаруй жил хайгуулын судалгааг хийн, өдгөө Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий Алтны Дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас Баян Хөндий, Алтан Нарыг хөгжүүлэлтэд шилжүүлэхээр зорьж байна. Мөн зүүн зүгт 40 км-т Компани Зуун Мод хэмээх 100% өөрийн эзэмшлийн томоохон зэс-молибденийн төслийг нээн илрүүлсэн.

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд Баян Хөндий төслийн талбайд өрөмдлөгийн судалгаагаар 158 г/т алтны агуулга бүхий 14 метрийн зузаан интервал, үүнээс 1 метр зузаан интервалд 2,200 г/т алтны өндөр агуулга илрүүлсэн. Алтан Нард 10.3 г/т алтны агуулга бүхий 20 метрийн зузаан интервал, түүнд 1 метрийн турш 101 г/т өндөр алтны агуулгыг илрүүлсэн. Энэхүү хоёр ордоос гадна Компани нь бүс нутгийн хайгуулын хөтөлбөрийг үргэлжлүүлэн, 2018 оны 4-р улиралд анхан шатны эдийн засгийн тооцооллыг боловсруулахаар төлөвлөж байна. Хэдийгээр хайгуулын анхан шатанд явж буй боловч энэхүү дүүрэг суурь болон үнэт металлын систем, зэс-алтны порфирууд, дундаж сульфиджилттэй/ карбонат суурь металлын алтны ордууд болон бага сульфиджилттэй эпитеpmал алт болон алт-мөнгөний системүүдийг багтааж байна.

Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Энэхүү хэвлэлийн мэдээнд дурдсан нөөцийн тайланг Хонгконгийн RPMGlobal-ийн мэргэжилтэн Жереми Кларк (Jeremy Clark)-ийн хяналт дор боловсруулсан. Ноён Кларк нь Австралийн Геосудлаачдын Институтын гишүүн (Дугаар 3567) бөгөөд NI 43-101 дагуу Мэргэшсэн этгээдийн шаардлагыг хангасан. RPM-ийн боловсруулсан Нөөцийн тайлан дахь мэдээлэл нь энэхүү хэвлэлийн мэдээнд тоймлогдсон бөгөөд хэвлэлийн мэдээг ноён Кларк хянасан болно. Энэхүү хэвлэлийн мэдээ нийтлэгдсэнээс 45 хоногийн дотор Баян Хөндий ордын Нөөцийн тайлан болон Техникийн тайлан нь SEDAR дахь Эрдэнэ Ресурсийн хуудас дээр тавигдана.

Майкл МакДоналд (Michael A. MacDonald) нь Компанийн Хайгуул эрхэлсэн дэд ерөнхийлөгч, мэргэшсэн геосудлаач (P.Geo.) (Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба энэ мэдээлэлд багтсан техникийн мэдээллийг хянан баталгаажуулсан болно Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдэцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэсэн.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх

бүхий 4 хайгуулын, 1 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй компани. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com -оос авч танилцах боломжтой. Компанийн тухай тодорхой мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрэх магадлалтай тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш болно. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал
Кэн В. МакДоналд, Дэд ерөнхийлөгч болон Санхүү хариуцсан захирал
Утас: (902) 423-6419
Емайл: info@erdene.com
Вебсайт: www.erdene.com
Твиттер: @ErdeneRes